



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот


МУИС-ийн багш, ажилтны  
хөгжлийг дэмжих үйл ажиллагааны  
санхүүжилтийн журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, МУИС-ийн Дүрмийн 4.3.1, 4.3.8.4 дэх хэсэг, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн хурлын 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МУИС-ийн багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журам”-ыг хавсралтаар баталж, батлагдсан өдрөөс эхлэн мөрдсүгэй.


2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төлөвлөлт хариуцсан дэд захирал /Б.Энх-Амгалан/, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал, холбогдох нэгжийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЧИРХУЯГ

Захирлын 2020 оны 01 дүгээр сарын 20 -ны  
өдрийн 4/49 дугаар тушаалын хавсралт



## МУИС-ИЙН БАГШ, АЖИЛТНЫ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 МУИС-ийн “Багш ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журам” (цаашид журам гэх)-ын зорилго нь Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль болон Монгол улсын багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэн хөдөлмөрийн харилцаанд оролцогч багш ажилтны хөгжлийг дэмжихэд шаардлагатай санхүүжилтийг төлөвлөх, зарцуулах нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

1.2 Багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ил тод, нээлттэй байх, хүлээх үр дүн бодитой, тодорхой байх, багш ажилтны жигд оролцоог хангана.

### ХОЁР. Багш, ажилтны хөгжлийг дэмжих санхүүжилтийн төлөвлөлт

2.1 Багш, ажилтны хөгжлийг дэмжих санхүүжилтийг дараах байдлаар төлөвлөнө.

- 2.1.1 Бүрэлдэхүүн /салбар/ сургууль нь бакалаврын сургалтын төлбөрийн орлогын 2 хувь, ахисан түвшний сургалтын төлбөрийн орлогын 1 хувиар тооцох,
- 2.1.2 Ахисан түвшний сургуулийн хувьд судалгааны магистр болон докторын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын багц цагийн төлбөрийн орлогын 1 хувиар тооцох,
- 2.1.3 Захиргаа, төвлөрсөн сангийн хувьд ерөнхий суурийн хичээлийн сургалтын төлбөрийн орлогын 1 хувиар тооцох,
- 2.1.4 БЭЛАС-ийн хувьд сурагчдын сургалтын төлбөрийн орлогын 2 хувиар тооцох,
- 2.1.5 Бие даасан нэгжүүдийн хувьд өөрийн нэгжийн төсвийн орлого, зарлагын нөхцөл байдалтай уялдуулан алдагдалгүй ажиллаж байгаа тохиолдолд нийт төсвийн орлогын 2 хүртэл хувиар тооцож болно.

2.2 Бүрэлдэхүүн сургуулийн захиргаа нь тэнхимд харьяалалтай хөтөлбөрүүд дэх идэвхтэй оюутны тоо, тэнхимээс зааж нийт хичээлд хамрагдаж буй оюутны тоо болон тэнхимийн багш нарын тоог харгалзан тэнхим тус бүрд төсвийн хэмжээг тогтоож өгнө. Тэнхим, нэгжид ногдох төсвийн 50 хувь нь багшийн тооноос, 25 хувь нь тэнхимд харьяалалтай хөтөлбөрүүд дэх идэвхтэй оюутны тооноос, 25 хувь нь тэнхимээс заадаг нийт хичээлд хамрагдаж буй оюутны тооноос хамаарна /Ахисан түвшний сургуульд энэ заалт хамаарахгүй/.

2.3 МУИС-ийн захирал, бүрэлдэхүүн /салбар/ сургуулийн захирал санхүүгийн жилийн эхэнд багш ажилтныг дэмжих төсөв, санхүүжилтийн хэмжээг баталж, холбогдох тэнхим, нэгжүүдэд хүргүүлнэ.

2.4 Багш, ажилтан нь дэмжлэг авах хүсэлтийг холбогдох тэнхим, нэгжийн удирдлагад гаргах ба хүний нөөцийн системд оруулсан багшийн хувийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн тэнхим, нэгж хэлэлцэж дүгнэлтийг Бүрэлдэхүүн /салбар/ сургуулийн захиргаанд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

### **ГУРАВ. Багш, ажилтны хөгжлийг дэмжих санхүүжилтийн зарцуулалт**

3.1 Батлагдсан төсвийг Монгол улсын их сургуулийн багшийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсанаар багшийн судалгааны цогц чадамж, сургалтын цогц чадамж, багш ажилтны хувь хүний эрүүл мэндийн үйлчилгээ, цогц чадамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.

3.2 Бүрэлдэхүүн /салбар/ сургуульд ногдох багш, ажилтныг дэмжих санхүүжилтийн зардлын 2/3-ыг тухайн тэнхимийн багш, ажилтны хөгжлийг дэмжихэд зарцуулна.

3.3 Бүрэлдэхүүн /салбар/ сургуулийн тухайн тэнхимд ногдох багш, ажилтныг дэмжих санхүүжилтийн зардлын 1/3-ийг багш, ажилтны хувь хүний цогц чадамжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийг дэмжихэд зарцуулна.

3.3.1 Хууль эрх зүй, эдийн засаг, мэдээллийн технологи болон бусад чиглэлээр мэдлэг дээшлүүлэхэд чиглэгдсэн богино хугацааны сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх,

3.3.2 Гадаад хэлний мэдлэг дээшлүүлэх богино хугацааны сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх,

3.3.3 Харилцаа, хандлага, ёс зүйн чиглэлээр сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх,

3.3.4 Бие бялдар чийрэгжүүлэх секц, дугуйланд хамрагдахад дэмжлэг үзүүлэх,

3.3.5 Эрүүл мэндийн болон урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах, рашаан сувиллаар үйлчлүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэх,

3.3.6 Эрхэлж буй ажил, албан тушаалтай холбоотой чиглэлээр боловсролын зэргээ ахиулахад дэмжлэг үзүүлэх.

3.4 Бүрэлдэхүүн /салбар/ сургуулийн тухайн тэнхимд ногдох багш, ажилтныг дэмжих санхүүжилтийн зардлын 1/3-ийг нийт багш нарын сургалтын цогц чадамжийг нэмэгдүүлэхэд зарцуулна.

3.4.1 Дотоод болон гадаадад мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх ,

3.4.2 Сурах бичиг хэвлэх, гарын авлага бэлдэх, сурах бичиг орчуулахад дэмжлэг үзүүлэх,

3.4.3 Тэнхим, нэгжээс сургалтын цогц чадамжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай гэж үзсэн бусад үйл ажиллагааг дэмжих.

3.5 Бүрэлдэхүүн /салбар/ сургуулийн тухайн тэнхимд ногдох багш, ажилтныг дэмжих санхүүжилтийн зардлын 1/3-ийг нийт багш нарын судалгааны цогц чадамжийг нэмэгдүүлэхэд зарцуулна.

- 3.5.1 Судалгааны ажлын ур чадвараа сайжруулах сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх /судалгааны арга зүй, өгүүлэл бичих, илтгэх хэвлүүлэх арга зүй, төслийн менежмент, судалгааны ёс зүй, академик судалгаа удирдах арга зүй/
- 3.5.2 Оюуны бүтээл /өгүүлэл хэвлүүлэх, зохиогчийн эрх авах, сэтгүүл гаргах/ хэвлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- 3.5.3 Сургалтын агуулгыг сайжруулахад чиглэсэн жижиг хэмжээний судалгааны ажил/төсөл хэрэгжүүлэх
- 3.5.4 Богино хугацаагаар гадаадад судалгааны ажил гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх
- 3.5.5 Эрдэм шинжилгээний хуралд оролцоход дэмжлэг үзүүлэх
- 3.5.6 Тэнхим, нэгжээс судалгааны цогц чадамжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай гэж үзсэн бусад үйл ажиллагааг дэмжих

3.6 Бүрэлдэхүүн /салбар/ сургуульд ногдох багш, ажилтныг дэмжих санхүүжилтийн зардлын 1/3-ийг багш, ажилтны хөгжлийг дэмжих бодлогын арга хэмжээ, бүрэлдэхүүн /салбар/ сургуулийн захиргааны ажилтнуудын хөгжлийг дэмжих хэлбэрээр захирал /дэд захирал/ болон захиргааны шийдвэрийг үндэслэн зарцуулна. Бүрэлдэхүүн /салбар/ сургууль дээр байгаа ТҮ4-ТҮ8 хүртэлх ажилтнуудын хувьд журмын 3.3 болон 3.4.1-д заасны дагуу дэмжлэг үзүүлнэ.

3.7 Захиргаа, төвлөрсөн санд ногдох ажилтныг дэмжих санхүүжилтийн зардлын 1/3-ийг ажилтны хөгжлийг дэмжих бодлогын арга хэмжээ хэлбэрээр нэгжийн захирал /дарга/-ын шийдвэрийг үндэслэн зарцуулна. Үлдэж буй 2/3-ыг ТҮ1-ТҮ3 ангилалд багтах үйлчилгээний ажилчдын хувьд журмын 3.3.3, 3.3.4, 3.3.5-д заасан дэмжлэгийг, ТҮ4-ТҮ9 ангилалд багтах ажилтны хувьд журмын 3.3 болон 3.4.1-д заасан дэмжлэгийг тус тус үзүүлнэ.

3.8 БЭЛАС-ийн хувьд өөрсдийн дотоод журмын дагуу багш, ажилчдын хөгжлийг дэмжих санхүүжилтээ зарцуулна.

#### **ДӨРӨВ. Дэмжлэг үзүүлэх нөхцөл, тавигдах шаардлага**

4.1 Багш, ажилтанд сургуулийн сургалт, судалгааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй нөхцөлд дэмжлэг үзүүлнэ.


4.2 Багш, ажилтан нь зөвхөн ажлын байрны тодорхойлолтод заагдсан мэргэшлийн бэлтгэл, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаагаар дэмжлэг авна.

#### **ТАВ. Хориглох заалт**

5.1 Санхүүжилтийг дараах байдлаар зарцуулахыг хориглоно. Үүнд:

- 5.1.1 Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах
- 5.1.2 Цалин, урамшуулал, шагнал хэлбэрээр авах
- 5.1.3 Багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардлыг өөр багш, ажилтанд шилжүүлэх
- 5.1.4 Сахилгын болон ёс зүйн зөрчил гаргасан багш, ажилтанд тухайн жилийн багш, ажилтныг дэмжих үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх

5.1.5 Багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардлыг дараагийн жилд шилжүүлэн хэрэглэх



### **ЗУРГАА. Багш, ажилтны хөгжлийг дэмжих санхүүжилтийн тайлагнал**

6.1 Багш нь багшийн хувийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу багш, ажилтны хөгжлийг дэмжих санхүүжилтийн зарцуулалтын гүйцэтгэлийг нотлох баримтын хамт хүний нөөцийн системд оруулсан байна.

6.2 Журмын 3.5.3, 3.5.4, 3.5.5-д тусгагдсан үйл ажиллагааны чиглэлээр багш дэмжлэг авсан тохиолдолд үр дүнг тэнхимийн семинараар хэлэлцүүлнэ.

6.3 Багш, ажилтан нь журмын 3 дугаар зүйлд тусгагдсан аливаа сургалтад хамрагдах дэмжлэг авсан тохиолдолд тухайн сургалтаар олгогдсон сертификат бусад дүйцэхүйц баримт бичгээр үр дүнг тэнхим, нэгжид тайлагнана.

6.4 Журмын 3.4.2, 3.5.2-д тусгагдсан үйл ажиллагааны чиглэлээр багш дэмжлэг авсан тохиолдолд үр дүнг тэнхимийн хурлаар хэлэлцүүлнэ.

6.5 Багш, ажилтанд үзүүлсэн дэмжлэг нь журмын 6.2, 6.3, 6.4-д заасны дагуу хэлэлцүүлээд шаардлага хангаагүй гэж үнэлэгдсэн тохиолдолд тухайн багш, ажилтанд дараагийн жилд сургуулийн зүгээс багш ажилтныг дэмжих үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэхгүй.

6.6 Багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны мэдээлэл, дэмжлэг үзүүлэх шийдвэр, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, санхүүжилтийн зарцуулалтыг тэнхим, нэгжүүд нээлттэй, ил тод мэдээлнэ.

6.7 Багш, ажилтны хөгжлийг дэмжих санхүүжилтийн тайланг захиргаа, төвлөрсөн сан, бүрэлдэхүүн /салбар/ сургууль бүр жилийн эцэст гаргана.

6.8 Захиргаа, төвлөрсөн сан, бүрэлдэхүүн /салбар/ сургуулийн багш, ажилтны хөгжлийг дэмжих санхүүжилтийн тайланг Санхүү, төлөвлөлт хариуцсан нэгжээс нэгтгэн хичээлийн жилийн тайланд тусгана.